**ТӨЛБӨР ХУРААХ ЦЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ**

**2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Аудитынтайлан**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:**


САГазрын дарга: Ц. Наранчимэг
Утас:261663

Аудитын менежер: Я. Самбууням
Утас: 260512

Аудитор: Б. Баярмаа
Утас: 260512

Үндэсний Аудитын Газар
Засгийн газрын |Үбайр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс
Цахим хуудас: www.audit.mn

“Юнистар” Аудит ХХК
Захирал: М.Энхжаргал
Утас:99168961328735
Цахим хаяг:
unistar_audit@yahoo.com
Аудитор:Н. Туяа
Утас:99168961



Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитынгэрчилгээ
Хавсралт 3: Менежментийнзахидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


**2016 оны 2 дугаар сар**

САГ/2017/63/ÑÒÀ-ТШЗ

## АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагынзорилго,үйлажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитынаргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтынсорилболоннарийвчилсангорим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Шилэн дансны мэдээлэл
8. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэнголзөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэнаудитаарилэрсэнзөрчлийннэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. **<u>Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:</u>**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн15 дугаар зүйлийн 15.1.1дүгээр заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төлбөр хураах цэгийн үйл ажиллагааны 2016оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /*САГ/2016/63/СТА-ТШЗ* / аудит хийлээ.

АудитыгТөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Төлбөр хураах цэгийн үйл ажиллагааны2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төлбөр хураах цэгийн үйл ажиллагааны2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугээр сарын 25-ныхугацаанд хийхээр төлөвлөн “Юнистар Аудит“ ХХК-ийнаудитор Н. Туяа, чанарын хяналтын менежер Д. Сүхээ, аудиторын туслах А. Өсөхбаяр, М.Цэцэгсүрэн нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төлбөр хураах цэг нь2016 оны санхүүгийн тайланг 2017оны 01дүгээр сарын 23-нд “ Юнистар Аудит ” ХХК-д ирүүлсэн.

“Юнистар Аудит “ ХХКнь аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017оны 02 дугаар сарын 25-нд Төлбөр хураах цэгийн удирдлагад гардуулна.

2. **<u>Байгууллагын хууль, эрх зүйн орчин:</u>**

Төсвийн захирагч нь Монгол улсын“Төсвийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”,"Авто замын тухай хууль”, Авто тээврийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн аудитын тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”,”Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-иуд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол,Зам тээврийн яамны сайдын тушаал, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

## 3. Байгууллагынзорилго,үйлажиллагаа:

Тус байгууллага нь Зам тээврийн хөгжлийн төвийн харьяа бөгөөд “Авто замын салбарт дэвшилтэд техник техонологи, инновацийг шинжлэх ухааны үндэслэлтэй нэвтрүүлэн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино” гэсэн зорилттой ажиллаж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол УлсынТөсвийн тухай хуулийн 16дугаар зүйлийн 16.1-д “Төсвийнбайгууллаганьтүүнийүйлажиллагаагүрашигтайудирдлагаархангахажлынүрдүнгхариуцахүүрэгбүхий төсвийн шууд захирагч байна. 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга /захирал эрхлэгч/ тухайн байгууллагын төсвийн захирагч байна” гэж заасны дагуу Төлбөр хураах цэгийнзахиралтөсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төлбөр хураах цэгийн2016 оны төсвийг Сангийн яамнытөрийн сангаас олгож байна.

Төлбөр хураах цэгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

## 4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитынаргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтынсорилболоннарийвчилсангорим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төлбөр хураах цэгийн2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан горим, сорил 28-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төвийн захирлын 2013-02-01-ний өдрийн А/06 тоот тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажилгаанд тохирууланмөрдөж байна. Тус газар нь Санхүүгийн тооцооллын ACOLOUS санхүүгийн програмаар санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байна.

Төлбөр хураах цэгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төлбөр хураах цэгийнсанхүүгийнүйлажиллагаагбүртгэх, хянах, боловсруулахүйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулансанхүүгийнтайланбэлтгэхаргачлалындагуутайлангаа бэлтгэсэнбайна.

5. **Материаллаг байдал:**

Бид санхүүгийн тайланд материаллаг байдлыг авч үзэхдээ Төсвийн орлогын хэмжээ байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлно гэж үзээд орлогын тайлангийн материаллаг түвшинг орлогын 1 хувиар буюу алдааг хүлээн зөвшөөрөх нийт хэмжээг 55.7 сая төгрөгөөр тооцоолов./ТАБ-СТА-В-1/

6. **Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.Төлбөр хураах цэгийндотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байлаа.

7. **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар**:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Зам тээврийн яамны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төлбөр хураах цэгийн төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс1,920.0 сая төгрөгийн урсгал зардалдбаталсан бөгөөд тус байгууллага нь 4,969.7 сая төгрөгийн өөрийн орлого, 597.0 сая төгрөгийн хөрөнгийн орлого нийт 5,566.8 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 5,931.8 сая төгрөгийн зарцуулж, Сангийн яаманд 4,625.0 сая төгрөгийгтөвлөрүүлсэн байна.

8. **Шилэн дансны мэдээлэл**

ТХЦ нь “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,нийтлэгстандартыг тогтоох тухай журам”, Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын дагуу

1.2016 оны жилийн эцсийн болон хагас жилийн тайлан баланс

2.Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан

3.2016 оны батлагдсан төсөв

4.2016 оны Төлбөр авах цэг /замын сан/-н орлого, үйл ажиллагааны зардлын 1-12 дугаар сарын төрийн сангаар баталгаажуулсан төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бусад мэдээ мэдээлэл 20 ширхэг, мэдээллийг, Зам тээврийн хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн

яам болон Сангийн яамны цахим хаягаар улирал бүрийн хуулийн хугацаанд тайлан мэдээг илгээж ажилласан байна. Үүнд тендерт оролцсон нарийн мэдээлэлийн тухай
1.Зам, тээврийн хөгжлийн яамны хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний сайдын 62,180 тоот тушаал
2.Тендерийн үнэлгээний хороо байгуулсан төвийн захирлын тушаал
3.Хэвлэл мэдээллийн болон вэйб сайтад тендер зарласан зар
4.Худалдан авах ажиллагааны тайланг гаргаж Зам, тээврийн яаманд хүргүүлсэн 1 удаа, 5 саяаас дээш худалдан авалт /Тендерийн худалдан авалт/-ын тухай 1 удаа,Цалингийн зардлаас бусад 5 саяаас дээш зардлыг 2 удаа, 5 саяаас дээш орлогыг 12 удаа, Хөрөнгө зарцуулах эрхийн акт, гэрээ, тушаалыг 4 удаа, Бусад мэдээлэлийг 10 удаа тавьсан байна.Цалингийн зардлаасбусад 5 саяаас дээш зардлыг 2 удаа, 5 саяаас дээш орлогыг 12 удаа, Хөрөнгө зарцуулах эрхийн акт, гэрээ, тушаалыг 4 удаа, Бусад мэдээлэлийг 10 удаа тавьсан байна.

## 9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан горим, сорил 28-ийг гүйцэтгэв.

## 10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төлбөр хураах цэгийн2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, ажил үйлчилгээний орлого, тээвэр шатахууны зардал, томилолт зочны зардал, засгийн газрын урсгал шилжүүлэг буюу засвар үйлчилгээний зардал, улсын мэдээллийн маягтын зардал зэрэг дансандажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 02 дугаар сарын 15-ны 103 тоот тогтоолоор “ Олон улсын болон улсын чанартай автозам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах журмаар төлбөрийн хэмжээг нэмсэнтэй холбогдуулан орлогын гүйлгээ нэмэгдсэн.

Төлбөр хураах цэгийн үндсэн хөрөнгө нь 929.7 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнээс барилга байгууламж 881.7 сая төгрөгөөр нэмэгдсэний 557.2 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын орлогоор нэмэгдсэн.

Тус байгууллага нь тайлант оны эхэнд 4,464.7 сая төгрөгийн авлагатай байсан бөгөөд 3,339.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 4,625.0 сая төгрөгийг сангийн төвөлрүүлснээр 3,179.0 сая төгрөгийн авалгатайгаар тайлагнасан байна.

## 11. Аудитаар илрүүлсэнголзөрчлүүд, тэдгээрийгшийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаархөндөгдсөнголасуудлуудыгдараахзаалтадхураангуйлантэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тус газар нь îíû ýõýíä 4,464.7 сая òºãðºãèéí àâëàãàòàé áàéñàí áà òàéëàíãèéí òàñàëáàð áîëãîñîí ºäðººð 3,179.0 сая òºãðºãèéí àâëàãàòàé òàéëàãíàñàí. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т ”Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.Авлага нь нийт хөрөнгийн 61.4%-ийг эзэлж байна.

   Шийдвэрлэсэн: Авлагаар тусгасан 3,179.0 сая төгрөгийг 2017 оны төсвийн тодотголд тусгуулах талаар Зам, тээврийн хөгжлийн яам болон Сангийн яаманд асуудлаа тавиад, тооцоо нийлж актаар баталгаажуулах саналаа хүргүүлсэн, мөн төлөвлөглөгөөнөөс давсан орлогоос хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг гаргаж Зам, тээврийн хөгжлийн яам болон Сангийн яаманд албан тоотоор удаа дараа хүргүүлж ирсэн байна.Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллахталаар аудитын зөвлөмж өгсөн.

2. Бараа материалын үлдэгдэл нь өмнөх оноос 9.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Төсвийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

   Шийдвэрлэсэн: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 57 дугаар тушаалаар шинээр 4 төлбөр авах цэг шинээр ашиглалтанд орж, үйл ажиллагааг эхлүүлсэнтэй холбоотой бараа материалын зардал өссөн байна.Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэх талаар аудитын зөвлөмж өгсөн.

**12. <u>Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:</u>**

Аудитын явцад он дамжин авлага 3,179.0 сая төгрөг, бараа материалын үлдэгдэл нь 9.4 сая төгрөгөөр нэмэгдсэн зэрэг алдаанууд залруулагдаагүй. Тус байгууллага нь 2017 онд төлөвлөглөгөөнөөс давсан орлогоос хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг гаргаж Зам, тээврийн хөгжлийн яам болон Сангийн яаманд албан тоотоор удаа дараа хүргүүлж ирсэн. Мөн 2017 оны төсвийн тодотголд 3.179,0 сая төгрөгийн тусгуулахаар талаар Зам, тээврийн хөгжлийн яам болон Сангийн яаманд асуудлаа тавиад, тооцоо нийлж актаар баталгаажуулах саналаа хүргүүлсэн байгаа тул алдааг залруулаагүй.

**13. <u>Анхаарал татахуйц бусад чухал асуудал:</u>**

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

**14. <u>Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:</u>**

Төлбөр хураах цэгийн2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. **<u>Санхүүгийн тайланд хийсэнаудитаарилэрсэнзөрчлийннэгтгэл</u>**:

Төлбөр хураах цэгийн2016 оны санхүүгийнтайланд хийсэн аудитаар илэрсэнзөрчлийг дахин давтахгүй байхыг зөвлөв.

**16. <u>Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:</u>**

Төлбөр хураах цэгийн2015 оны санхүүгийн тайланд 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмж үндсэндээ 50 хувийн биелэлттэй. Энэ нь тухайн байгууллагаас шалтгаалаагүй бөгөөд Сангийн сайдын 163 тоот тушаалаар олгогдох төсвийн урамшуулал олгогдоогүйтэй холбоотой байна.

**17. <u>Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:</u>**

**Зөрчилгүй саналдүгнэлт**

Төлбөр хураах цэгийн2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажилгүйлгээнүүдхолбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөвилэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан, менежементийн захидал, асуулгын бүртгэл, байгууллагын санхүүгийн тайлан болон судалгаа, саналын хуудсыг тус тус хавсаргав.

**ТӨЛБӨР ХУРААХ ЦЭГ**

**2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

**Тэргүүлэх ач холбогдол № 1**

**Тэргүүлэх ач холбогдол № 2**

**Асуудал 1**

**Авлагын талаар.................................3**

**Асуудал 2**

**Бараа материалын үлдэгдэл**

**өссөн талаар .......................................4**

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудитүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь Аудитын олон улсын стандарт болон аудитûн горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Төлбөр хураах цэгийн  хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимд зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хяналт хийсэн бөгөөд оршин буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан захирал, ерөнхий нягтлан бодогч бусад албаны дарга нар болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

| Асуудал 1: Авлага талаар | Тэргүүлэх ач холбогдол №2 |
|---|---|

Ажиглалт

Аудитын явцад ажиглахад тус байгууллага оны эхэнд 4,464.7 сая төгрөгийн авлагатай байсан ба тайлангийн тасалбар болгосон өдрөөр 3,179.0 сая төгрөгийн авлагатай тайлагнасан. Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр, төлбөр үүсгэхгүй байх" гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэл

Авлага өглөг нь удах тусам эрсдэл дагуулж байдаг. Он удаан жил болсон авлага нь хуучирч, мартагдах зэргээр найдваргүй болон эргэлзээтэй авлагыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Иж, Э, Ү

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн дагуу авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зарчмыг мөрдөн ажиллах

Төлбөр хураах цэгийн хариу

2017 онд төлбөр авах цэг /замын сан/-н төлөвлөглөгөөнөөс давсан орлогоос хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг гаргаж Зам, тээврийн хөгжлийн яам болон Сангийн яаманд албан тоотоор удаа дараа хүргүүлж ирсэн. 2017 оны төсвийн тодотголд 3.179,0 сая төгрөгийн т тусгуулахаар талаар Зам, тээврийн хөгжлийн яам болон Сангийн яаманд асуудлаа тавиад, тооцоо нийлж актаар баталгаажуулах саналаа хүргүүлсэн.

| **Асуудал 2: Бараа материалын үлдэгдлийн өсөлтийн талаар** | **Тэргүүлэх ач холбогдол №2** |
|---|---|

Ажиглалт

Бараа материалын үлдэгдэл нь өмнөх оноос 9.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Төсвийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэл

Бараа материалын нөөц их байх нь барааны чанар муудаж, хугацаа дуусах, зардал өсөх эрсдэлтэй. Ил, Х, Үн, Т

Зөвлөмж

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэх

Төлбөр хураах цэгийн хариу

Засгийн газрын 2016 оны "Журам батлах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 103 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 57 дугаар тушаалаар шинээр 4 төлбөр авах цэг шинээр ашиглалтанд орж, үйл ажиллагаа эхлүүлсэнтэй холбоотой бараа материалын зардал өссөн.Дээрхи зардлууд нь төлбөр авах цэгүүдэд одоо ашиглагдаж байгаа болно.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
**ТӨЛБӨР ХУРААХ ЦЭГ** 2016 оны 12-р сарын 31-ний байдлаар

*(Төгрөгөөр)*

| д/д | балансын зүйл | ТЭМ | Эхний үлдэгдэл | Аудитлагдсан |
|---|---|---|---|---|
| | Хөрөнгө | | | |
| | Эргэлтийн хөрөнгө | | | |
| | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | | - | 10,000.00 |
| | Кассад байгаа бэлэн мөнгө | | - | - |
| | Банкинд байгаа бэлэн мөнгө | | - | 10,000.00 |
| | Төсвийн харилцах | | | 10,000.00 |
| | АВЛАГА | | 4,464,698,389.00 | 3,179,000,000.00 |
| | Бусад байгууллагаас авах авлага | | 4,464,698,389.00 | 3,179,000,000.00 |
| | БАРАА МАТЕРИАЛ | | 7,288,207.00 | 17,160,706.00 |
| | Бэлэн бүтээгдэхүүн | | 825,567.00 | 1,248,366.00 |
| | Хангамжийн материал | | 6,355,640.00 | 15,805,340.00 |
| | Бусад | | 107,000.00 | 107,000.00 |
| | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 4,471,986,596.00 | 3,196,170,706.00 |
| | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | | | |
| | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | | 1,117,062,030.70 | 1,978,418,377.97 |
| | Биет хөрөнгө | | 1,117,062,030.70 | 1,978,418,377.97 |
| | барилга байгууламж | | 961,142,783.00 | 1,822,799,272.00 |
| | Хуримтлагдсан элэгдэл | | (56,215,527.29) | (69,639,358.85) |
| | машин тоног төхөөрөмж | | 220,107,200.00 | 280,589,700.00 |
| | Хуримтлагдсан элэгдэл | | (26,915,018.43) | (80,187,587.38) |
| | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 22,133,950.00 | 29,683,950.00 |
| | Хуримтлагдсан элэгдэл | | (3,191,356.58) | (4,827,597.80) |
| | Биет бус хөрөнгө | | - | - |
| | Программ хангамж | | 3,135,500.00 | 3,135,500.00 |
| | Хуримтлагдсан элэгдэл | | (3,135,500.00) | (3,135,500.00) |
| | Нийт эргэлтийн бус хөрөнгө | | 1,117,062,030.70 | 1,978,418,377.97 |
| | Нийт хөрөнгө | | 5,589,048,626.70 | 5,174,589,083.97 |
| | Өр төлбөр | | | |
| | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | | |
| | Богино хугацаат зээл | | | |
| | Өглөг | | 49,397,148.00 | - |
| | ажиллагсадтай холбогдсон тооцоо | | | - |
| | бусад өглөг | | 49,397,148.00 | - |
| | Богино хугацаат өр төлбөрийн дүн | | 49,397,148.00 | - |
| | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | | |
| | Урт хугацаат зээл | | | |
| | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | | - | - |
| | ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | | 49,397,148.00 | - |
| | ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧ | | | |
| | Засгийн газрын хувь оролцоо | | | - |
| | өмнөх үеийн үр дүн | | 3,947,130,594.44 | 5,539,651,478.70 |
| | Тайлант үеийн үр дүн | | 1,592,520,884.26 | (365,062,394.73) |
| | дахин үнэлгээний зөрүү | | | - |
| | ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН | | 5,539,651,478.70 | 5,174,589,083.97 |
| | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 5,589,048,626.70 | 5,174,589,083.97 |
| | | | - | - |

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
## ТӨЛБӨР ХУРААХ ЦЭГ

*/төгрөгөөр/*

| | | |
|---|---|---|
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 3,057,821,560.00 | 4,969,748,136.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 3,057,821,560.00 | 4,969,748,136.00 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | | 10,000.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 597,024,430.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН 1 | 3,057,821,560.00 | 5,566,782,566.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | |
| АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ | 899,907,640.00 | 939,503,552.80 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 813,149,231.00 | 845,512,650.00 |
| Нийгмийн даатгал | 86,758,409.00 | 93,990,902.80 |
| БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ | 565,250,535.74 | 4,992,341,407.93 |
| Тогтмол зардал | 29,206,372.00 | 45,140,795.00 |
| гэрэл цахилгаан | 24,502,367.00 | 37,486,395.00 |
| түлш халаалтын зардал | 4,704,005.00 | 7,654,400.00 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 536,044,163.74 | 4,947,200,612.93 |
| бичиг хэргийн зардал | 433,430.00 | 3,127,910.00 |
| Тээвэр шатахууны зардал | 43,078,587.00 | 63,226,300.20 |
| Шуудан холбооны зардал | 2,616,500.00 | 3,460,000.00 |
| Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл | 2,017,459.00 | 8,862,510.00 |
| Дотоод томилолтын зардал | 7,248,860.00 | 18,621,439.00 |
| маягт хэвлүүлэх зардал | | - |
| зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | 3,052,000.00 | 25,183,000.00 |
| төлбөр, хураамж, жижиг татварууд | | - |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | 21,021,949.50 | 71,121,535.00 |
| Аж ахуйн материал худалдан авах зардал | | - |
| урсгал засварын зардал | 735,500.00 | 14,980,113.00 |
| бусад зардал | | 20,253,900.00 |
| элэгдлийн зардал | 7,434,588.24 | 68,332,641.73 |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 445,304,490.00 | 4,624,991,704.00 |
| нэг удаагын тэтгэмж урамшуулал | 3,100,800.00 | 25,039,560.00 |
| шагнал урамшуулал | | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,465,158,175.74 | 5,931,844,960.73 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 1,592,663,384.26 | (365,062,394.73) |
| Бусад хөрөнгө | 142,500.00 | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 142,500.00 | |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 1,592,520,884.26 | (365,062,394.73) |

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
## ТӨЛБӨР ХУРААХ ЦЭГ

/төгрөгөөр/

| | ТЭМ | Өмнөх он | Аудитлагдсан |
|---|---|---|---|
| ТАТААС БА САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН ОРЛОГО | | 1,938,713,714.00 | - |
| Улсын төсвөөс | | - | - |
| урсгал | | | - |
| ЗГНХ, засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адил | | | - |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид | | | - |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | | - |
| Төсвийн хэмнэлт | | 1,938,713,714.00 | - |
| БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | | 3,057,821,560.00 | 4,969,758,136.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | | 3,057,821,560.00 | 4,969,748,136.00 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | | | 10,000.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН 1 | | 4,996,535,274.00 | 4,969,758,136.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | | |
| АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ | | 850,510,492.00 | 988,900,700.80 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 813,149,231.00 | 845,512,650.00 |
| цалин | | 813,149,231.00 | 845,512,650.00 |
| цалингийн тусгай нэмэгдлүүд | | | - |
| Нийгмийн даатгал | | 37,361,261.00 | 143,388,050.80 |
| тэтгэвэр болон тэтгэврийн шимтгэл | | 37,361,261.00 | 143,388,050.80 |
| БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ | | 4,146,024,782.00 | 3,980,847,435.20 |
| Тогтмол зардал | | 29,206,372.00 | 45,140,795.00 |
| гэрэл цахилгаан | | 24,502,367.00 | 37,486,395.00 |
| түлш халаалтын зардал | | 4,704,005.00 | 7,654,400.00 |
| цэвэр бохир усны зардал | | | - |
| Бусад бараа үйлчилгээний зардал | | 4,116,818,410.00 | 3,935,706,640.20 |
| бичиг хэргийн зардал | | 433,430.00 | 3,425,110.00 |
| Тээвэр шатахууны зардал | | 43,078,587.00 | 63,226,300.20 |
| Шуудан холбооны зардал | | 2,616,500.00 | 3,460,000.00 |
| Дотоод томилолтын зардал | | 7,248,860.00 | 18,621,439.00 |
| жижиг эд хогшил худалдан авах зардал | | 1,197,460.00 | 15,811,010.00 |
| зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | | 3,052,000.00 | 25,183,000.00 |
| төлбөр, хураамж, жижиг татварууд | | | - |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр | | 21,331,899.00 | 83,713,834.00 |
| маягт хэвлүүлэх зардал | | | - |
| урсгал засварын зардал | | 985,500.00 | 33,197,113.00 |
| Ажэ ахуйн материал худалдан авах зардал | | | - |
| бусад зардал | | | 20,253,900.00 |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | | 1,162,077,509.00 | 304,482,059.00 |
| Засгийн газрын төвлөрүүлэн буцаан таталт | | 2,871,695,865.00 | 3,339,293,315.00 |
| нэг удаагын тэтгэмж урамшуулал | | 3,100,800.00 | 25,039,560.00 |
| Шагнал урамшуулал | | | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН | | 4,996,535,274.00 | 4,969,748,136.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | - | 10,000.00 |
| биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал | | | - |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН | | - | - |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | - | - |
| САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | - | - |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | - | 10,000.00 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | - |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | 10,000.00 |
| | | - | - |

## АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
## ТӨЛБӨР ХУРААХ ЦЭГ

*/төгрөгөөр/*

| | Засгийн газрын оруулсан капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний сан | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| | MNT | MNT | MNT | MNT |
| 2015 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл | | | 5,539,651,478.70 | 5,539,651,478.70 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | - |
| тайлант хугацаанд нэмэгдсэн | | | | - |
| үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | - |
| үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| | | | | - |
| тайлант үеийн үр дүн | | | (365,062,394.73) | (365,062,394.73) |
| 2016 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 5,174,589,083.97 | 5,174,589,083.97 |

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
## ТӨЛБӨР ХУРААХ ЦЭГ

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 1,919,961,900.00 | 4,969,748,136.00 | (3,049,786,236.00) | 258.85 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,919,961,900.00 | 4,969,748,136.00 | (3,049,786,236.00) | 258.85 |
| Бараа үйлчилгээний зардал | 1,919,961,900.00 | 4,969,748,136.00 | (3,049,786,236.00) | 258.85 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **1,651,120,000.00** | **988,900,700.80** | 662,219,299.20 | 59.89 |
| Үндсэн цалин | 1,432,757,500.00 | 845,512,650.00 | 587,244,850.00 | 59.01 |
| **Ажил олгогчоос төлөх НДШ** | **218,362,500.00** | **143,388,050.80** | 74,974,449.20 | 65.67 |
| **Бараа үйлчилгээний зардал** | **268,841,900.00** | **3,980,847,435.20** | (3,712,005,535.20) | 1,480.74 |
| **Тогтмол зардал** | **48,966,000.00** | **45,140,795.00** | 3,825,205.00 | 92.19 |
| Гэрэл цахилгаан | 37,966,000.00 | 37,486,395.00 | 479,605.00 | 98.74 |
| Түлш халаалт | 11,000,000.00 | 7,654,400.00 | 3,345,600.00 | 69.59 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **219,875,900.00** | **3,935,706,640.20** | (3,715,830,740.20) | 1,789.97 |
| Бичиг хэрэг | 4,255,000.00 | 3,425,110.00 | 829,890.00 | 80.50 |
| Тээвэр, шатахуун | 61,550,000.00 | 63,226,300.20 | (1,676,300.20) | 102.72 |
| Шуудан холбоо | 3,920,000.00 | 3,460,000.00 | 460,000.00 | 88.27 |
| Дотоод албан томилолт | 10,900,000.00 | 18,621,439.00 | (7,721,439.00) | 170.84 |
| Нормын хувцас зөөлөн эдлэл | 15,600,000.00 | 25,183,000.00 | (9,583,000.00) | 161.43 |
| Урсгал засвар | 13,275,000.00 | 14,980,113.00 | (1,705,113.00) | 112.84 |
| Маягт хэвлүүлэх зардал | 15,500,000.00 | 16,650,500.00 | (1,150,500.00) | 107.42 |
| Бусдаар гүйцэтгээүлсэн бусад нийтлэг ажил үйлчи | 61,061,900.00 | 65,949,644.00 | (4,887,744.00) | 108.00 |
| банкны үйлчилгээний хураамж | 780,000.00 | 708,650.00 | 71,350.00 | 90.85 |
| тавилга | | 7,550,000.00 | (7,550,000.00) | |
| багаж техник хэрэгсэл | | 10,667,000.00 | (10,667,000.00) | |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 13,200,000.00 | 25,039,560.00 | (11,839,560.00) | 189.69 |
| Аж ахуйн материал худалдан авах зардал | 13,900,000.00 | 15,811,010.00 | (1,911,010.00) | 113.75 |
| Төлбөр хураамж, жижиг татварууд | 360,000.00 | 405,040.00 | (45,040.00) | 112.51 |
| Бусад зардал | 5,574,000.00 | 20,253,900.00 | (14,679,900.00) | 363.36 |
| Төсөвт төвлөрүүлэх орлгоо | | 304,482,059.00 | (304,482,059.00) | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,339,293,315.00 | (3,339,293,315.00) | |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,800,000,000.00 | 4,969,758,136.00 | (169,758,136.00) | 103.54 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос | 4,800,000,000.00 | 4,969,748,136.00 | (169,748,136.00) | |
| туслах үйл ажиллагааны орлогоос | | 10,000.00 | (10,000.00) | |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | | | - | |
| **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 10,000.00 | (10,000.00) | |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| АЖИЛЛАГСАД БҮГД | 111.00 | 111.00 | - | 100.00 |
| Удирдах ажилтан | 16.00 | 16.00 | - | 100.00 |
| үйлчлэх ажилтан | 95.00 | 95.00 | - | 100.00 |
| гэрээт ажилтан | | | - - | |
| | | - | | |

Бэлтгэсэн: Аудитор Н. Туяа Огноо:

2016 оны 02-р сарын 14-ны өдөр